

**БОЛГООМЖГҮЙГЭЭР ХОР УРШИГ ХАМТРАН УЧРУУЛАХ ҮЙЛДЛИЙН  
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ**  
CRIMINAL LEGAL PROBLEMS OF ACTS THAT CAUSE UNINTENDED HARMFUL  
EFFECTS

Н.Сайнбаяр  
*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн  
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах  
багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

**Товч агуулга:** Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг нэмэгдүүлдэг нэг үзүүлэлт нь гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэртэй байдаг. Гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцох асуудал зөвхөн гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдсэн гэмт хэрэгт л тодорхойлогддог шинж юм.

Гэвч дан ганц санаатай гэлтгүй, болгоомжгүй гэмт хэрэгт хэд хэдэн этгээд өөрийн үйлдлээр хор уршигт хүргэх тохиолдол байсаар байна. Хамтран оролцох асуудал нь зөвхөн санаатай гэмт хэрэгт хэрэглэгддэг тогтсон ухагдахуун тул болгоомжгүй гэмт хэрэгт хамт оролцож байгаа үйл явцыг “хамтын үйл ажиллагаа” хэмээн нэрших шаардлагатайг тодорхойлж, үүнтэй холбоотой эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хүрээн дэх тулгамдаж буй асуудлыг энэхүү өгүүлэлээр хөндөж, шийдлийг боловсруулсан.

**Түлхүүр үгс:** Гэм буруугийн хэлбэр, болгоомжгүй гэмт хэрэг, гэм хор учруулах, хамтран оролцох.

**Abstract:** In criminal law, one of the indicators that increases the social danger of a crime is the form of complicity in the crime. The problem of complicity in committing a crime is a characteristic that is determined only in crimes committed with the intention of guilt. However, life is rich, and there are cases when several individuals, not only intentional, but also reckless crimes, cause harm through their actions. Since the problem of complicity is a well-established concept used only in intentional crimes, it is necessary to call the process of complicity in reckless crimes “joint action”, and this article addresses the relevant issues in the field of criminal law and develops solutions.

**Keywords:** Types of guilt, reckless crime, causing harm, and participating in the crime.

**Үндсэн хэсэг**

Аливаа улс орны зүгээс иргэдийнхээ эрүүл аюулгүй байдлыг хангах нь нэн тэргүүний хэрэгжүүлэх үүрэг бөгөөд энэ талаар манай улсын Үндсэн хуульд: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна<sup>1</sup>” гэж тунхаглан заажээ. Энэ нь эрх зүйн хүрээнд бий болсон эргэлзээ бүхий нөхцөл байдлыг шинээр хэм хэмжээ бүтээх замаар тасралтгүй зохицуулах замаар илэрхийлэгдэнэ. Нийгмийн харилцаанд шуурхай зохицуулах шаардлагатай харилцаа байсаар байна. Тухайлбал, болгоомжгүйгээр хор уршиг хамтран учруулах асуудал юм.

Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр нь зөвхөн санаатай гэмт хэрэгт л хэрэглэгддэг гэсэн хэвшмэл ойлголт өрөөсгөл болох нь судалгааны үр дүн харуулав. Энэ чиглэлээр судлах болсон

---

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

шалтгаан нь судлаачийн хувьд практикт ахлах мөрдөгчөөр ажиллах хугацаанд нэгэн гэмт хэрэг бүртгэгдсэн юм. Тодруулбал, А ХХК нь өөрийн эзэмшлийн газарт үйлчилгээний байгууламж барихаар болж 380 вольтын өндөр хүчдэлийн шугам татуулахаар Б ХХК-д захиалга өгч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулав. Б ХХК нь өндөр хүчдэлийн шугамыг газрын гүнээр шугамыг явуулж, үйлчилгээний газрыг ашиглалтад оруулжээ. Тухайн цахилгааны шугам нь В ХХК-ний үйлчилгээний төвийн талбайгаар дамжин өнгөрч байсан бөгөөд В ХХК нь үйлчилгээний талбайгаа хүрээлсэн төмөр хашааг Г ХХК-наар хийлгэжээ. Г ХХК нь өндөр хүчдэлийн шугам явж буй хэсэг дээр өрөмдлөг хийж хашааг суурилуулсан. Тухайн хашаа нь оршин суугчдын хөдөлгөөнийг хязгаарлаж байсан тул явцын дунд хашааны нэг шонг авч түүгээр тэр хавийн орчин суугчид орж гарч явдаг байв. Ийнхүү тодорхой хугацаанд тухайн хашааг нэвтэрч өнгөрөх тусам хашаа хөдөлж, суурь хэсэг нь цахилгааны шугамыг гэмтээж гүйдэл дамжив. Энэ үед амь хохирогч К нь тухайн хашааны гарцаар гарах гэж төмрөөс барьж өндөр хүчдэлд цохиулж амь насаа алдсан.

Шалгалтын явцад Б ХХК нь цахилгааны шугамыг газрын гүнд 1 метрийн зайд булж, П хэлбэртэй бетон хамгаалалт хийх ёстой байсан боловч 50 см гүнээр, бетон хамгаалалтын оронд улаан тоосгоор П хэлбэртэй хаалт хийж шугамыг далдалж журам зөрчсөн, үүнд А ХХК нь хяналт тавих үүрэгтэй байсан боловч гүний хяналтыг хэрэгжүүлээгүй, мөн В ХХК нь кадастрын зураг зөрчиж хашаа барьсан, Г ХХК нь газар шорооны ажил хийхдээ орчны инженерийн шугам сүлжээний талаарх мэдээллийг аваагүй зэрэг зөрчлүүд илэрчээ. Эдгээр 4 хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтнууд хууль тогтоомжид заасан өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлээгүй улмаас хохирогч нас барсан нь тогтоогдсон бөгөөд анх удаа болгоомжгүй гэмт хэрэгт хамтын үйл ажиллагааны хэлбэр байх боломжтойг ойлгож мэдсэн. Үүний үр дүнд холбогдох судалгааг хийхэд болгоомжгүй гэмт хэргийн хамтын үйл ажиллагааны талаарх ойлголт, үзэл баримтлал байсныг тодорхойлж чадсан.

Энэ ухагдахуун нь үндэсний эрх зүйн тогтолцоонд шинэхэн мэт боловч олон улсын түвшинд нэн шинэ ойлголт биш юм. Тодруулбал, болгоомжгүйгээр хор уршиг хамтран учруулах боломжтой талаар ОХУ-ын зарим судлаачдын бүтээлд тэмдэглэгдсэн байна<sup>2</sup>.

Үүнийг болгоомжгүй гэмт хэрэгт хамтран оролцох<sup>3</sup>, болгоомжгүй гэмт хэрэг дэх хамтын үйл ажиллагаа<sup>4</sup> г.м-ээр олон янзаар тодорхойлсон боловч үндсэн агуулга нь нэг л ойлголтыг илэрхийлэхийг зорьсон болох нь энэ чиглэлийн судалгаануудаас тодорхой харж болох юм. Судлаачийн зүгээс болгоомжгүйгээр хор уршиг хамтран учруулах гэх нэр томъёо нь ухагдахууныг бүрэн дүүрэн илэрхийлж, мөн чанарыг оновчтой тодорхойлсон гэж үзлээ.

Дээрх жишээнээс үзэхэд, үйл явцын оролцогч нэгний болгоомжгүй үйлдэл дангаараа хор уршигт хүргээгүй бөгөөд хэд хэдэн этгээдийн болгоомжгүй үйлдлүүд “хамт” бий болсны үндсэн дээр хор уршигт хүрсэн нь тодорхой харагдаж байна. Аль нэг этгээдийн үйлдэл үгүй бол хор уршигт хүргэх боломжгүй. Тиймээс болгоомжгүй гэмт хэргийн хамтын үйл ажиллагаа нь “гарцаагүй хамт байж” сая хор уршигт хүргэх онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, хор уршигт хүргэсэн хэд хэдэн болгоомжгүй үйлдлүүдийн, хэн нэгэн этгээдийнх нь үйлдэл, эс үйлдэхүй үгүй бол тухайн болгоомжгүй гэмт хэрэг гарцаагүй үгүйсгэгдэх шинжээр илэрхийлэгдэнэ.

<sup>2</sup> Трайнин А. Н. Учение о соучастии. М., 1941. С. 11; Шаргородский М. Д. Вопросы Общей части уголовного права. Л., 1959. С.

<sup>3</sup> Бохан А. П., Петрашева Н. В. Соучастие в неосторожном преступлении: миф или реальность? // журнал Лекс Россия. 2016 №5. С.217.

<sup>4</sup> Безбородов Д, А. К вопросу о понятии неосторожного сопричинения в уголовном праве. Криминалистика. 2014. №1. С.9-16.

Өөр нэгэн жишээг авч үзвэл, барилгын талбайд өндрийн өргөгч төхөөрөмжийн операторт буулгах, өргөх команд өгч байсан ажилтан ачааг буулгах талаар дохио өгөхөд оператор түүнийх нь дагуу ачааг буулгахад дор нь ажилтан байсан нь дарагдаж гэмтсэн. Команд өгч байсан ажилтны байрлалаас тухайн хохирсон ажилтныг харах боломжтой байсан бөгөөд оператор зөвшөөрсөн хэмжээнээс их хэмжээний ачаа ачсанаас мөн дор нь байсан хэсэг талбай харагдах боломжгүй байсан.

Мөн залуу хосууд хөгжилдөхөөр шийдэж, тээврийн хэрэгслийг жолоодон явсан эрэгтэй нь жолоочийн суудлын ард, хааз дээр хөлөө тавьж хурдыг тохируулж, харин эмэгтэй нь түүний өвөр дээр зорчих хэсэг рүү харж, жолооны хүрдийг барьж хөдөлгөөнд оролцож байгаад явган зорчигч Б-г мөргөж хүнд гэмтээсэн.

Эдгээрээс үзэхэд, болгоомжгүй хэд хэдэн үйлдлийн нийлэмжийн үр дүнд нэг гэмт хэрэгт үйлдэгдэж байна. Харин аль нэг нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага тодорхой болохоос гадна, хор уршигт хүргэхгүй байх боломжтойг харж болох юм. Гинжин хэлхээсээр нэгдэж сая нэг гэмт хэрэг болдог онцлогтой.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэм буруугийн болгоомжгүй хэлбэр нь хөнгөмсгөөр найдах, хайхрамжгүй хандах гэсэн үндсэн 2 төрөлтэй. Эдгээр нь оюун ухамсрын болоод хүсэл сонирхлын түвшнээр тодорхойлогддог<sup>5</sup>.

Оюун ухамсрын түвшин нь а/ ямар хэмжээгээр гэмт этгээд өөрийн үйлдлийн нийгмийн аюулын шинжийг ухамсарлаж байсан, б/ ямар хэмжээгээр гэмт этгээд өөрийн үйлдлийн аюулын шинжийг урьдчилан мэдэж байсан эсэхээр илэрхийлэгддэг бол хүсэл сонирхлын түвшин нь гэмт этгээдийн чиглэмж, гүйцэтгэлийг тодорхойлдог.

#### *Хөнгөмсгөөр найдах*

| Оюун ухамсрын түвшин                                     | Хүсэл сонирхлын түвшин                                                                                                                                               |
|----------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Өөрийн үйлдлийн нийгмийн аюулын шинжийг урьдчилан мэддэг | Бодитой, бүрэн бус тооцооллын үр дүнд өөрийн болон бусдын нөхцөл байдлыг буруугаар дүгнэж хор уршигт хүргэхгүй байж чадна гэсэн итгэл үнэмшлээр хор уршигт хүргэдэг. |

Хөнгөмсгөөр найдах нь шууд бус санаатай гэм буруугийн төрлөөс зөвхөн хүсэл сонирхлын түвшнээр ялгагддаг. Хөнгөмсгөөр найдах үед тооцоолол хийсвэр байдаг. Жишээ нь өвлийн улиралд хөдөө замд элэгдсэн дугуйтай 55 км/ цаг хурдтай явж байгаа тээврийн хэрэгсэл жолоодож явсан жолооч өөрийн жолоодлогын туршлагад найдаж, осол гаргахгүй байж чадна гэж тооцоолж улмаар халтиргаа үүссэн хэсэгт жолоодлого алдаж малчин Б-г хүнд бэртээж буйг ойлгож болно. Харин шууд бус санаагийн үед малчин Б-г мөргөж гэмтээх гэсэн зорилгоо анхнаасаа тодорхойлж, тээврийн хэрэгслээ жолоодож явахаар илэрхийлэгдэнэ.

#### *Хайхрамжгүй хандах*

| Оюун ухамсрын түвшин                                                                 | Хүсэл сонирхлын түвшин <sup>6</sup>                                             |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------|
| Гэмт этгээд өөрийн үйлдлийн нийгмийн аюулын шинжийг ухамсарладаггүй, хор уршиг учирч | Өөрийн үйлдлийн нийгмийн аюулын шинжийг ухамсарлаагүй, урьдчилж хараагүй боловч |


<sup>5</sup> Бобраков И, А, Бекморвин М,Т., Горелкина Н,А., Осокин Р, Б., Рогожин А, А., Симоненко А, В., Тарасов Н,В., Телегин А,А. Уголовное право Российской Федерации. Учебник. Брянская обл. 2008. С.96-97.

<sup>6</sup> Хайхрамжгүй хандахын оюуны ухамсрын түвшнийг объектив ба субъектив шинжээр тодорхойлдог. Объектив шинж нь тухайн хүний үүрэг, өөрөөр хэлбэл, хийх **ёстой** байсан. Субъектив шинж нь хувь хүнийх нь онцлогоос хамаарч хор уршигийн талаар эргэцүүлэн бодох, урьдчилан харах **боломжтой** байсан эсэхээр тодорхойлогдоно. Ёстой болоод боломжтой байсан хоёр шинжийг хамтад нь тодорхойлсны үндсэн дээр л эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

|                                                           |                                                                           |
|-----------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|
| болох эсэхийг урьдчилан хараагүй байснаар илэрхийлэгдэнэ. | ухамсарлах, урьдчилж харах ёстой болон боломжтой байснаар илэрхийлэгдэнэ. |
|-----------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|

Болгоомжгүй гэмт хэрэг дэх хамтын үйл ажиллагааны үед гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийн эдгээр шинжүүдийг тодорхойлох бөгөөд ингэхдээ дараагийн гэмт этгээдийн үйлдэл тодорхойлно. Өөрөөр хэлбэл, болгоомжгүй хамтын ажиллагааг бүрдүүлж буй үйлдэл бүхэн нэг нэгнээ нөхцөлдүүлдэг тул хор уршигт хүргэсэн нийлмэл үйлдлийн оролцоог нотолж тогтоох нь л чухал. Ингэхдээ хор уршиг учирсан мөчөөс эхлэн буцах замаар гэм буруугийн болгоомжгүй хэлбэрүүдийг нэг бүрчлэн тодорхойлох нь оновчтой.

Энэхүү үзэл баримтлал нь объектив талын үндсэн шинж болох шалтгаант холбооны онолуудтай зөрчилдөх нь мэдээж. Тухайлбал, гэмт этгээдийн үйлдэл л хор уршигт шууд хүргэсэн байна гэсэн шалтгааны холбоог хангах шаардлагатай. Гэтэл болгоомжгүй хамтын үйл ажиллагааны хүрээнд нэг үйлдэл нөгөөг нөхцөлдүүлж хамтдаа нэг хор уршигт хүргэдэг.



Тийм учраас л болгоомжгүй гэмт хэрэг дэх хамтын үйл ажиллагааны хүрээнд оролцогч этгээдүүдэд хүлээлгэх хариуцлага хүртэл бага байх ёстой. Учир нь дангаараа хор уршигт хүргээгүй бөгөөд бусдын болгоомжгүй үйлдлүүдтэй нөхцөлдсөний үр дүнд гэмт хэрэг үйлдэгдсэн тул гүйцэтгэлийн хэр хэмжээ бага байх нь мэдээж. Өөрөөр хэлбэл, хэд хэдэн үйлдлийн нийлэмж нэг гэмт хэрэгт тооцогдож байгаа тохиолдолд түүнд хүлээлгэх хариуцлага нь харьцангуй бага байх учиртай.

Энэхүү бичил судалгааны үндсэн дээр болгоомжгүйгээр хор уршиг хамтран учруулах үйлдэлд дараах шинж зайлшгүй гэж үзсэн. Үүнд:

1. Гэм хор хамтран учруулж байгаагаа оролцогчид мэдэхгүй. Энэ нь хамтын үйл ажиллагааны үндсэн шинж байна. Хэн нэгэн оролцогч бусад оролцогчийн үйлдлийг тооцоолж үйлдсэн бол хамтын үйл ажиллагаа гэж үзэхгүй.
2. Хамтын үйл ажиллагааны үр дүнд л зөвхөн гэмт хэрэг үйлдэгдсэн, хор уршиг учирсан байна. Өөрөөр хэлбэл, оролцогчийн үйлдэл болгон гэмт хэрэг үйлдэгдэхэд хувь нэмэр оруулсан, өөр хоорондоо нөхцөлдсөн байна. Нэг оролцогчийн үйлдэл үгүйсгэгдвэл гэмт хэрэг үгүйсгэгдэнэ.
3. Болгоомжгүй гэмт хэрэг дэх хамтын үйл ажиллагааг бүрдүүлж байгаа үйлдэл, эс үйлдэхүй бүр гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийн шинжийг бүрэн хангасан байна.

4. Хамтран учруулсан оролцогчид хүлээлгэх хариуцлага харьцангуй бага байх ёстой зэрэг болно.

### Дүгнэлт

Судалгааны ажлын үр дүнд дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Энэ талаар олон улсын түвшинд судлагдсан боловч Монгол Улсын хэмжээнд болгоомжгүйгээр хор уршиг хамтран учруулах асуудал судлагдаагүй, цаашид дэлгэрүүлэн судлах хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлов. Энэ нь бусдын гэм буруутай үйлдлийг оновчтой зүйлчлэх боломжийг бүрдүүлнэ.

2. Нийгмийн харилцаанд болгоомжгүйгээр хор уршиг хамтран учруулах асуудал багагүй тохиолддог боловч тохирсон хууль эрх зүйн шийдэл байхгүйгээс хүний эрх эрх чөлөө зөрчигдөх үндсэн суурь болжээ. Өөрөөр хэлбэл, аливаа хүний хэсэгчлэн оролцсон үүргээс гэмт хэрэг шууд үйлдэгдээгүй боловч бусдын оролцоог харгалзахгүйгээр тохирсон ял оногдуулж чадахгүй байна.

3. Болгоомжгүйгээр хор уршиг хамтран учруулах үйлдлийг оновчтой тодорхойлохын тулд түүнд агуулагдах үндсэн дөрвөн шинжийг зайлшгүй тогтоох нь эрүүгийн хариуцлага шударга байх зарчимд нийцүүлэх ач холбогдолтой. Үүнд: Гэм хор хамтран учруулж байгаагаа оролцогчид мэдэхгүй, Хамтын үйл ажиллагааны үр дүнд л зөвхөн гэмт хэрэг үйлдэгдсэн, хор уршиг учирсан, болгоомжгүй гэмт хэрэг дэх хамтын үйл ажиллагааг бүрдүүлж байгаа үйлдэл, эс үйлдэхүй бүр гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийн шинжийг бүрэн хангасан, хамтран учруулсан оролцогчид хүлээлгэх хариуцлага харьцангуй бага байх ёстой зэрэг болно.

4. Судалгааны үр дүнд нэр томъёог “Болгоомжгүйгээр хор уршиг хамтран учруулах” гэж оноох нь илүү оновчтой, ухагдахууны мөн чанарыг илэрхийлсэн гэж судлаачийн зүгээс үзлээ. Учир нь хамтран оролцох гэдэг нь Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд санаатай гэмт хэрэгт хэрэглэгддэг нь тогтсон ойлголт, харин болгоомжгүй гэмт хэргийг хамтын үйл ажиллагааны үндсэн дээр үйлдэж байгаа тохиолдолд өөр нэршил, ухагдахуун ашиглах нь зүйн хэрэг юм.

## Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он;
2. Эрүүгийн хууль 2015 он;
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он;
4. Сайнбаяр, Н. Мөрдөн шалгах ажиллагаа. Нэг сэдэвт бүтээл. Уб.,2024;
5. Конституция Российской Федерации /принята всенародным голосованием 12.12.1993 с изменениями, одобренными в ходе общероссийского голосования 01.07.2020/;
6. Безбородов Д, А. К вопросу о понятии неосторожного сопричинения в уголовном праве. Криминалистъ. 2014. №1.
7. Бохан А. П., Петрашева Н. В. Соучастие в неосторожном преступлении: миф или реальность? // журнал Лекс Россия. 2016 №5.
8. Бобраков И, А, Бекморвин М,Т., Горелкина Н,А., Осокин Р, Б., Рогожин А, А., Симоненко А, В., Тарасов Н,В., Телегин А,А. Уголовное право Российской Федерации. Учебник. Брянская обл. 2008.
9. Трайнин А. Н. Учение о соучастии. М., 1941
10. Шаргородский М. Д. Вопросы Общей части уголовного права. Л.,1959.
11. Цахим эх сурвалж: <https://legalinfo.mn/>;